

ДОТООДЫН

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ**



2025.10.27

Дотоодын зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- Монгол улсын зээлжих зэрэглэлийг “BB-” болго тогтоолоо
- CUMN болон QPAY хувьцаануудын арилжааны идэвх 10-р сард тогтмол нэмэгдлээ
- Эрдэнэ Ресурс ХК 3-р улирлын тайлангаа 11-р сарын 4-нд танилцуулна

МХБ-ийн индексийн өгөөж

Индекс	Долоо хоног	Сар	Жил
ТОП 20	1.96%	0.92%	25.47%
MSE A	2.11%	-0.01%	20.27%
MSE B	0.08%	-0.97%	34.89%

2025/10/27 – 2025/10/31

Идэвхтэй арилжаалагдсан үнэт цаас

Симбол	Үнийн дүн
TGI	1,000,735,608.00
KHAN	603,780,582.00
APU	441,275,319.87
MSE	235,383,957.37
ERDN	179,414,290.00

2025/10/27 – 2025/10/31

Өндөр өсөлттэй үнэт цаас

Симбол	Хаалтын ханш	Өсөлт %
OLL	26.00	14.04%
MIK	16,250.00	12.97%
HVL	161.99	11.72%
BUK	335.00	11.67%
SHV	2,800.00	8.15%

2025/10/27 – 2025/10/31

2025 он 11-р сарын 03

Зах зээлийн
үнэлгээ тэрбум ₮

13,051

ТОП-20 индекс

49,782

MSE A

19,356

MSE B

14,352



МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ өсөлт

5.6%

2025 - III улирал

Инфляц

9.0%

2025-09 сар

ГВУН(сая\$)

5,874.52

2025-09 сар

Бодлогын
хүү

12.0%

ЗГ-ын бондын
өгөөж

6.6%

USD/MNT

3,585.29

2025-11-02

 **Эдийн засгийн мэдээлэл****МОНГОЛ УЛСЫН ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛИЙГ ВВ- БОЛГОЛОО**

Олон улсын S&P агентлаг 2025 оны аравдугаар сарын 30-нд Монголын үнэлгээг “BB-, тогтвортой” болгож ахиулсныг зарлав. Энэ нь сүүлийн 13 жилийн дараа өмнөх өндөр түвшиндээ эргэн хүрсэн чухал үйл явдал юм.

Сайжруулахад нөлөөлсөн гол шалтгаанууд:

- Төвлөрсөн төсөв сайжирсан – 2022 оноос хойш уул уурхайн экспорт өссөнөөр төсвийн гүйцэтгэл мэдэгдэхүйц сайжрав.
- Эдийн засгийн тогтвортой өсөлт болон өрийн удирдлага зөв хэрэгжсэн – Засгийн газрын өр/ДНБ харьцаа буурав.
- Дунд хугацаанд эдийн засаг тогтвортой өсөлтөө хадгална, төсвийн алдагдал бага хэвээр байна гэж S&P үзэж байна.
- Улс төрийн орчинд өөрчлөлт гарсан ч төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдал үргэлжилнэ гэж үнэлэв.

Бусад агентлагуудын үнэлгээ:

- Fitch Ratings – “B+, тогтвортой” хэвээр
- Moody’s – “B2”-оос “B1, тогтвортой” болгон ахиулсан
- S&P – 2 жил дараалан ахиулж, одоо “BB-, тогтвортой”

Монгол Улс “өрийн өндөр эрсдэлтэй” ангиллаас гарч “харьцангуй аюулгүй, хөрөнгө оруулалтын эрсдэл багатай” түвшинд шилжив. Гадаад санхүүжилтийн өртөг, зээлийн хүү буурах боломж сайжирна. Банк, санхүүгийн байгууллага, хувийн хэвшлийн зээлжих чадвар нэмэгдэнэ. Гадаадын хөрөнгө оруулагчдын итгэл өснө, хөрөнгө оруулалт татах таатай орчин бүрдэнэ.

QPAY БОЛОН CUMN КОМПАНИУДЫН АРИЛЖААНЫ ИДЭВХ 10-Р САРД ӨНДӨР БАЙЛАА

MSE: CUMN хувьцаа 10-р сард 14 орчим хувиар өсөж IPO ханшаасаа дээш гараад байна. Мөн арилжааны идэвхи нь тоо ширхэгээр 1,024,249-д хүрч эрэлт нэмэгдсээр байгаа билээ.

MSE: QPAY хувьцаа 10-р сард 8 орчим хувиар өсөж арилжааны идэвхи нь 1,252,447 ширхэгт хүрч 10-р сардын топ гурван идэвхтэй хувьцаа боллоо.

ЭРДЭНЭ РЕСУРС НЬ 3-Р УЛИРЛЫН ТАЙЛАНГ 2025 ОНЫ 11 САРЫН 4-НД ТАНИЛЦУУЛНА

Эрдэнэ Ресурс Девелопмент Корп. (TSX:ERD; MSE:ERDN; OTCQB:ERFCF) (“Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани”) нь 2025 оны 11 сарын 4-ний өдөр хөрөнгийн бирж хаагдсаны дараа 3-р улирлын тайланг нийтэлнэ. Компанийн удирдлага 2025 оны 11 сарын 5-ны 10 цагт (Канадын зүүн эргийн цагийн бүсээр) вебкаст хийж, тайлантай холбоотой мэдээлэл танилцуулна.

Зах зээлийн мэдээлэл

ТОП-20 БА ПРЕИУМ НЭКСУС ХК (MSE:CUMN) ҮНЭЛГЭЭ

График 1. ТОП-20 ба CUMN үнэлгээний харьцуулалт





График 2. ТОП-20 ба CUMN үнэлгээнд үндэслэсэн ханш



CUMN хувьцааны үнэлгээний үзүүлэлтийг ТОП-20 индексийн үнэлгээтэй харьцуулж үзэн ханшийн таамаглалыг тооцож үзвэл хамгийн багадаа 245₮, хамгийн ихдээ 357₮-т хүрэх боломжтой гэж таамаглаж байна. Мөн P/E харьцаа дунджаас доогуур байна.


ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛ ЭХЭЛСНЭЭС ХОЙШ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН ДУНДАЖ ХАНШ 183.2₮

График 3. CUMN хувьцааны ханш



ДОТООДЫН ХУВЬЦААНД ХЭЗЭЭ ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ВЭ?

ТОП-20 индексийн сарын дундаж хэлбэлзэл (2015-2025)



Монголын ТОП-20 индексийн дундаж хэлбэлзлээс харахад 1-3 сар, 7-9 сар, 12 саруудад өсөлт давамгайлдаг байна.

Ямар стратеги баримтлах вэ?

- Ногдол ашиг хүртэхийг зорьж буй бол 1-3 сард хувьцаа худалдаж авах нь тохиромжтой.
- Хямд үнээр хувьцаа авах боломж хайж байгаа бол 4-5 сард зах зээлийн уналтыг ашиглах хэрэгтэй.
- 7-9 сард зах зээл өсөх магадлалтай тул эрт худалдан авч, өсөлтийг ашиглах боломжтой.
- Жилийн эцэст (12-р сар) дунд хугацааны өсөлт ажиглагдах хандлагатай тул урт хугацааны хөрөнгө оруулалтад тохиромжтой үе.

ВАЛЮТЫН ХАНШИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Хэрэв нүүрсний үнэ 10%-иар буурч экспортын орлого 800 сая ам.доллараар багасна гэж үзвэл: 2026 онд инфляц 0.7 нэгж хувиар нэмэгдэхтэй уялдан төгрөгийн ханш ам.долларын эсрэг 3-5% орчим сулрах магадлалтай.

График 1. Төгрөгийн ам.доллартай харьцах ханш

